



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/225

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 20,074,590.00 (хорин сая далан дөрвөн мянга таван зуун ер) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтын дагуу балансаас баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг хөрөнгө шилжүүлэн авч буй байгууллагуудын удирдлагад даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В.Оюумаа

В.ОЮУМАА



1150502066

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 419 дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуриутлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Нөөтбүүк	Dell	2017.11.28	ш	1	6,000,000.00	6,000,000.00	0.00	6,000,000.00	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
2	Нөөтбүүк	Lenovo	2023.12.04	ш	1	7,989,000.00	7,989,000.00	2,884,916.65	5,104,083.36	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар
Машин тоног төхөөрөмжийн дүн										
1	Дарга ширээ		9/9/2012	ш	1	1,021,900.00	13,989,000.00	2,884,916.65	11,104,083.36	Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ
2	Хурлын ширээ		1/25/2013	ш	1	890,000.00	1,021,900.00	0.00	1,021,900.00	
3	Шкаф		9/9/2012	ш	1	504,900.00	890,000.00	0.00	890,000.00	
4	Шкаф		8/1/2012	ш	1	554,390.00	504,900.00	0.00	504,900.00	
5	Сандал		6/6/2014	ш	5	339,900.00	554,390.00	0.00	554,390.00	
6	Дарга сандал		2/20/2017	ш	1	539,900.00	1,699,500.00	0.00	1,699,500.00	
7	Хивс		12/31/2011	ш	1	432,000.00	539,900.00	0.00	539,900.00	
8	Хивс		3/31/2010	ш	1	443,000.00	432,000.00	0.00	432,000.00	
Тавилга, эд хогшлын дүн						443,000.00	443,000.00	0.00	443,000.00	
Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн							6,085,590.00	0.00	6,085,590.00	
							20,074,590.00	2,884,916.65	17,189,673.36	